

ЗХА-ИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮЙЛ ЯВЦ, ТҮҮНД МОНГОЛ УЛС ОРОЛЦОХ НЬ

*МУИС, ОУХС-ийн дэд профессор,
доктор (Ph.D) С.Отгонбаатар*

Дэлхий нийтийн хөгжлийг тэргүүлэх хандлага Ази тив рүү шилжин, ХХI зуун Азийн зуун болно хэмээн олонхи улс төрчид, эдийн засагчид тодорхойлж, нэн ялангуяа ЗХА-ийн бүс /Монгол улс багтаж байгаа/ энэ дүгнэлтийг хэрэгжүүлэхэд зүтгүүрийн үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.

Зүүн Хойд Ази нь өөрийн боломжоороо дэлхийн бусад бүс нутгуудтай өрсөлдөх чадвартай бүс нутагт тооцогддог. Зургаан орныг хамарсан энэ бүс нутаг нь Хятадын Зүүн хойд хэсэг, Япон, Солонгосын хойг, Монгол, Оросын дорнод хэсгийн асар уудам газар нутаг, байгалийн арвин их баялаг, хямд ажиллах хүч, аж үйлдвэрлэлийн их нөөц, томоохон зах зээлийн багтаамжийг агуулсан зэрэг олон давуу талтай. Гео-эдийн засгийн талаасаа ч энэ бүс нутагт илүү их хөрөнгө оруулалт хийж гишүүн орнууд нь харилцан бие биенээ нөхөн хөгжих ихээхэн боломж бий бөгөөд ирээдүйн хөгжил цэцэглэлт нь гишүүн орнуудын улс төр, эдийн засгийн харилцан хамаарал бүхий хамтын ажиллагаанаас ихээхэн шалтгаална. Энэхүү хамтын ажиллагааг хөгжүүлэх, бүс нутгийн орнуудын харилцан бие биенээ нөхөн хөгжих боломжийг нээн илрүүлэх талаар судалгааны байгууллагууд идэвхтэй ажиллаж шинэ шинэ санаа оноо дэвшүүлэн, олон улсын хурал зөвлөлгөөн байнга зохиож, судалгааныхаа ажлыг дүгнэн хэлэлцдэг болоод байна.

ЗХА-ийн орнуудын олон талт хамтын ажиллагааны үндэс нь юуны өмнө бүс нутгийн орнуудын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээнд тулгуурласан эрчим хүч, зам тээврийн нэгдсэн сүлжээ болон чөлөөт бүс байгуулах зэрэг олон улсын томоохон төслүүдийг хэрэгжүүлэх явдал гэж үзэж байна.

Олон улсын төслүүд

Эрчим хүч

Өнөөдөр дэлхийн эрчим хүчний балансад нефть - 39%, байгалийн хий - 25%, нүүрс - 25%, ус болон цөмийн эх үүсвэр -11% тус тус эзэлж байна. ¹ ЗХА –ийн орнууд нь эрчим хүчний эх үүсвэр болох эдгээр нөөцөөр баялаг бөгөөд бүс нутгийн орнуудын байнга өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг бодолцвол энэ салбарт хамтын ажиллагааны ихээхэн ирээдүй харагдаж байна.

¹ Asia's new Dynamics of Energy supply/ demand in the 21st century, NEA economic forum, Dr. Fereidun Fesharaki, electricity summit in Hokuriku, Japan 2001 page5

ЗХА-д эрчим хүчний хэрэгцээ 2010 он гэхэд 1995 оныхоос 60-65 хувиар өсөх төлөвтэй бөгөөд Дорнод Сибирь, Алс Дорнодоос жилд 50 тэрбум кв/цаг-ийн эрчим хүч экспортлох боломжтой байгаа нь бүс нутгийн эрчим хүчний нэгдсэн сүлжээ байгуулах сонирхлыг ч төрүүлэх болов. Үүнд Эрхүүгээс Монголоор дамжуулан Хятадад, Сахалин болон Сахагаас Японд эрчим хүч нийлүүлэх өндөр хүчдэлийн шугам барих төслүүд яригдаж Ази Номхон Далайн эрчим хүчний судалгааны төв /APERCS/-д судалгааны ажил хийгдэж байгааг дурьдаж болно.²

Сүүлийн үед аливаа бүс нутаг, улс орны хөгжлийн асуудлыг байгаль орчинтой холбон ярих болсноор эрчим хүчний эх үүсвэрүүдийн төрөлд ч зарим өөрчлөлт орж байна. Үүнийг эрчим хүчний эх үүсвэрт байгалийн хийн хэрэгцээ нилээд өсөн нэмэгдэж байгаагаар тайлбарлаж болох юм. Японы Мицубиши судалгааны хүрээлэнгээс Хойд Сахалин, Саха, Иркутск болон Туркменистаны байгалийн хийн ордуудаас хоолой татаж Хятад, Өмнөд Солонгос, Японы хэрэгцээг хангахаар тооцоолсон байна. Эдгээр хийн хоолойг дараахи хувилбаруудаар сонгон авч тооцоо судалгааг гаргажээ³. Үүнд:

А. Ашхабад -Өрөмч -Ланьжоу -Сиань, Ляньюган -Мокло -Киктакюшо

Б. Саха - Аян - Сахалин - Вакканай.

В. Эрхүү -Улаанбаатар -Бээжин - Шэньян, Пхеньян -Сеул - Пусан - Китакюшо

ЗХА -ийн байгалийн хийн хэрэгцээний 2010 оны төлвийг улс тус бүрээр авч үзвэл⁴:

1. ОХУ-ын Алс Дорнодын хязгаар	115
2. БНХАУ	45 - 136
3. Япон	75.7- 86.7
4. БНСУ	28.7 - 35.5
5. Монгол	0.3
6. БНАСАУ	9.7
Нийт	383.2

тэрбум шоо метр /bcm/

Харин байгалийн хийн томоохон нийлүүлэгч ОХУ-ын үйлдвэрлэлийн хэмжээ 2010 – 2020 онд ямар байхыг дараахи үзүүлэлтээс харж болно.

Баруун Сибирь	665	700
Дорнод Сибирь	28	61
Алс Дорнод	26	54
Нийт	719	815

тэрбум шоо метр /bcm/

Үүний зэрэгцээ нефть нийлүүлэх асуудлаар ч яригдаж байгаа томоохон төслүүд бий. Жишээлбэл 2001 оны сүүлчээр ОХУ, БНХАУ-ын

² Ц.Батбаяр. Зүүн Хойд Ази ба Монгол, Улаанбаатар 2001, 43 дахь тал

³ International Conference on NEA. Natural gas pipeline, Tokyo, Japan 1998 page8

⁴ A long-term vision of natural gas trunkline in NEA, NEA Gas & Pipeline forum, Sep 2000 page 112, 115

хооронд 2.4 мянган км нефть дамжуулах хоолойг 2005 он гэхэд барьж байгуулахаар тохиролцлоо. Энэ төслийг хэрэгжүүлснээр Хятадад жил бүр 20 –30 сая тонн нефть нийлүүлэгдэнэ. Харин ОХУ-аас Хятад болон ЗХА-ийн бусад орнуудад нефть болон байгалийн хий нийлүүлэх эдгээр томоохон төслүүдэд Монгол Улс тус бүс нутгийн орны хувьд оролцох сонирхолтой байдаг. Нефть хийн хоолойг байгуулах төслийн зарим хувилбарыг ч Монголын нутаг дээгүүр дайруулан өнгөрүүлэхээр тооцоолсон нь бий.

Гэвч өнөөгийн байдлаар ЗХА-ийн хийн хоолойн зарим хэсэг Монголын нутгаар дайран өнгөрөх асуудал төдийлөн дэмжигдэхгүй байгаад дараахи нөхцөл, шалтгаан нөлөөлж байна гэж үзэж болох байна. Үүнд:

1. Хятад улс худалдан авагчийн хувьд хийн хоолойг хөгжлөөр хоцронгуй байгаа нутгийн зүүн хойд хэсгээр дамжуулах сонирхолтой,

2. Хятадын зүүн хойд мужууд нүүрс ихээр хэрэглэж байгаа нь ЗХА-ийн байгаль орчныг ихээр бохирдуулж улмаар Японд муугаар нөлөөлж болзошгүй гэдэг үүднээс хийн хоолойг Хятадын зүүн хойд нутгаар дамжуулахыг Япон эсэргүүцдэггүй,

3. Монгол улс өөрийн ашиг сонирхлоо бодитойгоор илэрхийлж бусад орны дэмжлэг авч чадахгүй байгаа гэх мэт.

Зам, тээврийн харилцаа.

ЗХА-ийн олон талт хамтын ажиллагаанд зам тээврийн асуудал чухал үүрэгтэй бөгөөд бүс нутгийн орнууд хөгжлийнхөө ирээдүйг бодолцон нэгдсэн сүлжээ байгуулах, түүнд аль болох өргөн хамрагдах сонирхолтой байна.

10-аад жилийн өмнөөс энэ бүс нутгийн орнууд хоёр талын яриа хэлэлцээний үндсэн дээр хоорондоо худалдаа, аялал жуулчлалыг өргөжүүлэх үүднээс дотоодын зам харилцаа, тээврийн нөхцлийг сайжруулахад ихээхэн анхаарч ирлээ.

Гэтэл эдүгээ бүс нутгийг хамарсан нэгдсэн сүлжээ байгуулахаас гадна гурав дахь орнуудтай холбогдсон замын сүлжээний тухай ч нилээд яригдах болжээ. ОХУ-Япон, Хятад-ОХУ-Япон гэсэн гол чиглэлийн замуудыг байгуулах эхний төлөвлөгөө нь бүс нутгийн хүрээнээс хальж Европ, Хойд Америктай холбогдсон замын нэгдсэн сүлжээ байгуулах асуудалтай илүү уялдах болсныг дэлхийн улс орнуудын хооронд харилцан шүтэлцээ бүхий нэгдмэл тогтолцоог үүсгэж буй глобаль үйл явцын илрэл гэж хэлж болно. 1994 онд Грекийн Grete хотод Пан-Европын зам тээврийн асуудлаар Европын орнууд хуралдаж 9 чиглэлээр холбосон тээврийн сүлжээ байгуулахаар шийдвэрлэсэн нь бүс нутгийн төдийгүй Өрнө-Дорнын улс түмнийг холбох ирээдүйн санааг улам бататгав. Үүнийг Grete corridor гэж нэрлэх болсон юм.

Харин мэргэжилтнүүдийн тооцоолж байгаагаар ЗХА-ийн тээврийн сүлжээ нь ирээдүйд Европын замын сүлжээ буюу Грэтийн сүлжээтэй холбогдох бололтой. ЗХА-ийн эдийн засгийн бүсийн чуулган, түүний зохион байгуулах хорооны дэргэдэх тээврийн асуудал эрхэлсэн салбар

зөвлөлөөс /2000-оны 6 сард байгуулагдсан/ мөн 9 чиглэлээр тээврийн сүлжээний төлөвлөгөө боловсруулаад байна.⁵ Үүнд:

- | | |
|---|--|
| 1. Тайшет –Ваниногийн коридор | /Сибирийн төмөр зам /СТЗ/-Тайшет –Ванино/ |
| 2. Сибирийн төмөр замын коридор | /Европ–Приморскийн боомт, ОХУ/ |
| 3. Суйфэнхэгийн коридор | /СТЗ- Забайкалск- Манжоули- Харбин- Суйфэнхэ- Приморскийн боомт/ |
| 4. Түмэн голын коридор | /СТЗ –Дорнод Монгол -Чангчун- Түмэн гол/ |
| 5. Дайланы коридор | /СТЗ–Владивосток –Хэйхэ –Харбин – Дайлан/ |
| 6. Монгол –Тэнжиний коридор | /СТЗ–Улаанбаатар–Бээжин–Тэнжин/ |
| 7. Хятадын төмөр замын коридор | /Европ –Казакстан –Лианюнган боомт/ |
| 8. Солонгосын хойгийн баруун эргийн коридор | /СТЗ –Харбин –Шэньян - Шиниюжи – Пхенянь – Сэул –Бусан/ |
| 9. Солонгосын хойгийн зүүн эргийн коридор | /СТЗ –Хабаровск –Хасан – Ражин Сонбон – Пусан/ |

Энд тээврийн коридор гэсэн нэр томъёо нь төмөр зам, засмал замын тээврийн маршрут гэсэн утга санааг илэрхийлэхээс гадна тээврийн зохицуулалт, үйлчилгээ зэрэг бусад нөхцлүүдийг ч багтааж байгаа юм.

Түмэн бүсийн хөтөлбөр

ЗХА-ийн бүс нутагт хэрэгжүүлж болох олон улсын томоохон төслүүдээс 1991 оноос НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр эхэлсэн Түмэн голын сав газрыг хөгжүүлэх буюу 20 жилд 30 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж, цоо шинэ хөгжлийн бүс байгуулах төслийг ЗХА-ийн хамтын ажиллагааны бодит эхлэл гэж үзэх болсон билээ.

10-аад жилийн хугацаанд Түмэн голын сав газарт БНСУ, Тайланд, Япон, АНУ, Зүүн Өмнөд Азийн орнуудаас оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 1.5 миллиард ам.долларт хүрсэн байна. Эдгээр хөрөнгө оруулалтын дийлэнх буюу 520 сая нь БНХАУ-ын Жилин мужийн Янбины тойрогт, 535 сая нь ОХУ-ын Алс дорнодын Приморийн хязгаарт тус тус оржээ.⁶

Мөн НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс 8 сая ам. доллар, дэлхийн хүрээлэн байгаа орчныг хамгаалах байгууллагаас 5 сая ам.долларын хөрөнгө оруулаад байна.

⁵ <http://www.erina.or.jp>

⁶ Tumen update October 2000, Issue 3, page 12

Чөлөөт бүс

Эдийн засгийн чөлөөт бүс нь тухайн орон эдийн засгийн хөгжлөө хурдасгах зорилгоор сонгон авсан газар нутагтаа гааль, худалдаа, татварын хөнгөлөлттэй нөхцлийг олгож ажиллуулдаг тусгай бүс бөгөөд энэ нь тухайн орны хувьд эдийн засгийн туршилтын талбар болж байдаг. Өөрийн онцлог нутгууддаа дэд бүтцийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг төвлөрүүлэх үүднээс голдуу хөгжиж буй орнууд энэ аргыг ихэвчлэн хэрэглэдэг байна.

ЗХА-ийн бүс нутагт 1990-ээд оноос ОХУ, БНХАУ, БНАСАУ-ууд эдийн засгийн чөлөөт бүс хэд хэдийг нээн ажиллуулсан юм.

Үүнд:

Хятад:	Манжоули, Сүйфэньхэ, Хуньчин, Уокука
БНАСАУ:	Ражин-Сонбон
ОХУ:	Владивосток-Находка, Чита, Сахалин

Гэвч эдгээр чөлөөт бүсүүд өнөөг хүртэл эрчимтэй хөгжихгүй байгаа бөгөөд шалтгааныг янз бүрээр тайлбарлаж байна.

Тухайлбал: Хятад улс дэд бүтэц сайн хөгжөөгүй, БНАСАУ хөрөнгө мөнгө дутагдалтай, ОХУ улс төр, эдийн засгийн байдал тогтворгүй байгаагаас шалтгаалж байна гэж үздэг.

Үүнээс гадна тухайн бүс нутгийн улс бүрт чөлөөт бүсийн төслийг удирдан зохицуулагч нь төр засгийн буюу орон нутгийн гэсэн ялгаатай түвшинд байдгаас адил тэгш, хамтын ажиллагааны харилцаа тогтоож чаддаггүй гэж үздэг. Жишээ нь ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд чөлөөт бүсийн төслийг удирдан зохицуулах түвшнийг орон тус бүрээр авч үзвэл:

Япон	- Орон нутгийн засаг захиргаа
Солонгос	- Төв Засгийн газар
Хятад	- Орон нутгийн засаг захиргаа
ОХУ	- Орон нутгийн засаг захиргаа
Хойт Солонгос	- Төв Засгийн газар
Монгол	- Төв Засгийн газар

Харин эндээс үзэхэд Өмнөд Солонгос, Хойт Солонгос, Монголын хоорондох хөгжлийн төлөвлөгөө нь төр засгийн төсөл байх бөгөөд эдгээр орны хувьд засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр байгуулж хамтран ажиллахад дөхөмтэй харагдаж байна.

Банк санхүү

Өнөөг болтол Зүүн Хойд Азид үйлчилдэг санхүүгийн ямар нэг байгууллага байхгүй учраас Зүүн Хойд Азийн Хөгжлийн банк байгуулах бодит шаардлага гарч байгаа бөгөөд ийм банк байгуулах санаа сүүлийн жилүүдэд нилээд эрчимтэй яригдах болов.

Шинэ банк нь хөрөнгийн зуучлалын гол үйл ажиллагааг зохицуулахаас гадна Азийн Хөгжлийн банк, Дэлхийн банктай нягт хамтран ажиллаж үндсэн капиталдаа тулгуурлан зээлийн туслалцаа үзүүлэх, санхүүгийн гадаад зах зээлд облигаци гаргах зэргийг шийдэх юм

байна. Хөгжиж байгаа гишүүн орнуудад бага хүүтэй зээл олгох тухай яригдаж байгаа бөгөөд үйл ажиллагаагаа бүрэн эхэлсэн тохиолдолд жил бүр 1-2 тэрбум ам.долларын зээл өгч болох тооцоо гаргажээ. ЗХА-ийн Хөгжлийн Банкны үйл ажиллагаа жигдэрмэгц санхүүгийн зуучлалын шинэ хэлбэр гарч ирэх болно. Тэр тохиолдолд Зүүн Хойд Ази, Түмэн голын хөрөнгө оруулалтын корпораци (NEATIC)-г байгуулах тухай ч яригдаж байна. NEATIC-ийн дээрх банкнаас ялгагдах онцлог нь хувийн секторуудад хөнгөлөлтэй зээл олгох ба улсын чанартай дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх гол зорилготой⁷.

Гэвч "Түмэн гол" төслийн хүрээнд өнөө үеийг хүртэл хийгдсэн ажил, хамаарч байгаа улс орны газар нутаг, оролцогч орнууд, шийдвэрлэхээр тавьсан зорилтуудын хэрэгжилт удаашралтай байгаа тухай нилээд яригдаж байна. Энэ байдлаас харвал Монгол улс уг төслийн оролцогчийн хувьд өөрийн орны болон бүс нутгийн ашиг сонирхлын үүднээс цаашдын хэрэгжилтэнд санаачлагч, идэвхтэй дэмжигч байдлаар оролцох нь зүйтэй болов уу. Уг төслийг цаашид өргөжүүлэх тухайд:

а) "Түмэн гол" төслийг жинхэнэ Зүүн хойд Азийн орнуудын хамтын ажиллагаа, интеграцийн талбар болгохын тулд, **нэгдүгээрт**, хамаарч буй газар нутгийг тэлэх, **хоёрдугаарт**, санхүү, техник, технологийн өндөр чадавхи бүхий Япон мэтийн бусад орноор оролцогчдын тоог нэмэгдүүлэн тэдний ашиг сонирхлыг бий болгох, **гуравдугаарт**, төслийн хөрөнгө оруулалтыг төвлөрүүлэн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий банк байгуулах асуудлыг дэмжих, **дөрөвдүгээрт**, Зүүн хойд Азийн орнуудын засгийн газар хоорондын байгууллага байгуулан түүнд бүс нутгийн хөгжил, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаатай холбогдсон хөрөнгө оруулалт, гааль, татвар, хөнгөлөлт, ажиллах хүчний бодлогын асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг чиглэлээр ажиллуулах нь зүйтэй санагдана.

Монгол улс ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцоход дотооддоо интеграцийн бүтцийг бий болгох нь чухал

Дэлхий дахин улам интеграцид орж глобалчлагдаж байгаа өнөө үед Монгол улс дэлхийн бусад оронтой ямар харилцан хамааралтай байж ямар замаар улсаа хөгжүүлэх вэ? гэдэг асуудал юунаас чухал болж байна. Манай улсын хувьд АНД, түүний дотор ЗХА-ийн бүс нутгийн интеграцийн процесст нэгдэх асуудал чухал бөгөөд Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн хөгжил нь энэ бүс нутгийн цаашдын хөгжил, хамтын ажиллагаанаас ихээхэн хамааралтай юм.

Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд "ЗХА-ийн зам тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээнд нэгдэн орох ...Түмэн гол хөтөлбөрт оролцох бодлогыг олон улсын харилцаа, бүс нутгийн улс төрийн байдалтай нягт уялдуулж тэргүүлэх чиглэл зорилтыг нь

⁷ Financing closer economic ties in NEA, the case for a new financing facility prepared by Tumen secretariat, UNDP, October 1999

тогтоохдоо уян хатан хандаж байх... Бүс нутгийн интеграцид орох нөхцлийг юуны өмнө түүнд хамаарч буй орнуудтай хоёр талын харилцааг өргөтгөн хөгжүүлэх замаар бүрдүүлэх"-ээр заасан байдаг.

ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагаанд Монгол улс хэрхэн оролцох талаар өөрийн байр суурийг оновчтой тогтоож, хэтийн хөгжилдөө гадаад нөхцлийг үндэс болгон үндэсний бүхий л түвшин, бүтцийн давхаргад нухацтай уялдуулан сайтар боловсруулсан үзэл баримтлалыг тодорхойлох нь чухал.

Монгол улс өөрөө цаашид хөгжихийн тулд интеграцид нэгдэн оролцох нь зайлшгүй бөгөөд үүний тулд улс орны нийгмийн байдал, дотооддоо авч хэрэгжүүлж байгаа шинэчлэлийн үйл явцтай уялдуулсан тодорхой төлөвлөгөө, интеграцийн загварыг боловсруулж тодорхой үе шаттайгаар авч үзэх нь зүйтэй юм.

Үүнд:

1. Бүс нутгийн интеграцид нэгдэх шаардлага, үндэслэл
2. Өөрийн орны нөөц бололцоо, боломж
3. Чиглэл зорилго, хэрэгжүүлэх үе шат зэргийг тодорхойлж бүс нутгийн орнуудтай хоёр талын хамтын ажиллагааг бүхий л хэлбэрээр хөгжүүлж худалдааг өсгөх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хамтарсан объект байгуулах зэргээр ажиллах шаардлагатай.

Зах зээлийн эдийн засаг нь интеграцийн процессгүйгээр хэрэгжихгүй. Интеграцид оролцох нь зөвхөн хамтран ажиллах хэлбэр биш үнэ мөнгөний бодлого татвар, худалдааны хөнгөлөлтийг дэмжсэн бодлогыг тухайн орнуудтай ойртуулж хуульчилж өгөх явдал чухал байдаг.

Монгол улсын хувьд харьцангуй буурай хөгжилтэй, үндэсний үйлдвэрлэл болон эдийн засгийн салбарын бүтэц хөгжөөгүй учир санхүү эдийн засаг, технологийн асуудлуудыг бие даан шийдвэрлэх боломжгүй юм. Иймд эдийн засгаа босгоход дэлхий нийтийн туршлагад тулгуурлан интеграцийн янз бүрийн хэлбэрийг ашиглах нь зохистой. Үүнд:

- Таваарын солилцоо
- Шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн капиталын зах зээлд харилцах
- Үйлчилгээ үзүүлэх
- Хөгжилтэй орнуудад ажиллах хүч гаргах зэрэг интеграцийн хэлбэрүүд илүү өгөөжтэй байж болох юм.

Улс төрийн хувьд

Улс оронд интеграцийн процессыг амжилттай хэрэгжүүлэхэд улс төрийн хувьд нэгдмэл байх нь чухал. Монгол улсад төрийн дээд байгууллага болох Монгол улсын их хурал, Ерөнхийлөгч, түүний Тамгын газар, төрийн хууль ёсыг тогтоон журамлах Засгийн газар, гүйцэтгэн зохицуулах үүрэг эрэмбийг багтаасан төр засгийн үйл ажиллагааны тогтолцоог бүрэлдүүлж байгаа нь нийгмийн амьдрал, эдийн засгийн системийг шинэчлэх гол угтвар нөхцөл болно.

Ази-Номхон Далайн бүс нутгийн интеграцид Монгол улсыг түлхүү оруулж нэгэнт эхэлсэн зах зээлийн харилцааг богино хугацаанд төлөвшүүлэхэд төр засгийн үүрэг роль урьд урьдаас илүү онцгой болж

байна. Улс орны эдийн засгийн хөгжлийн өнөөгийн нөхцөлд гадаадын хүчин зүйлийн ролийг эрс нэмэгдүүлэхэд төрийн зүгээс зохицуулах механизмыг чадмаг ашиглах нь чухал бөгөөд энэ нь юуны өмнө дараахи асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэх ёстой. Улс орон даяар хэрэгжүүлж байгаа эдийн засгийн шинэ загвар нь юуны түрүүн эдийн засгийн интеграцийн олон хэлбэр дээр үндэслэгдсэн байх нь чухал бөгөөд субъектүүдийн хоорондын түншлэлийн хэлбэрийг оновчтой сонгож, нарийн бодож боловсруулахаас гадна тэдгээрийн эдийн засгийн хувьд бие биенээ нөхөн хөгжих зарчмыг онцгойлон авч үзэх шаардлагатай.

Зах зээлийн үед улс орны нийгэм, эдийн засгийн бүхий л амьдралыг төрөөс хуульчлан зохицуулж амжилтанд хүрч болдгийг бид Азийн зарим орнуудын туршлагаас мэдэх билээ.

Манай улсын хувьд үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хөдөлмөр зарцуулалт ихтэй үйлдвэрлэлийн уламжлалт аргыг өөрчилж шинжлэх ухаан, техникийн дэвшлийн тэргүүлэх чиглэлүүдэд илүү анхаарч хөрөнгө мөнгө, нөөц боломжийг аль болохоор нэгдмэл хүч болгохыг зорих, хүн рүүгээ хөрөнгө оруулалт хийх нь чухал бөгөөд энэ нь хөгжиж дэвшихийн эх булаг болох ёстой. Үүний тулд төрийн хүчийг хөгжлийн хүчин зүйл болгон ашиглах нь чухал.

Эдийн засгийн тогтолцооны хувьд төр, үйлдвэрлэгч, хэрэглэгчийн хоорондын эдийн засгийн харилцааг зохицуулах хуулиудыг төрөөс тогтоож нийгмийн амьдралын хэвийн нөхцлийг бүрдүүлэх нь төрийн зохицуулалтын үндэс болох юм.

Эдийн засаг, худалдааны бодлого.

Зах зээлийн хуулийн дагуу улс орны эдийн засгийг санхүүгийн аргаар удирдан зохицуулах системд шилжүүлэх нь зайлшгүй бөгөөд уг үйл явцын онцлог, түүнчлэн зах зээлийн шилжилтийн үеийн эдийн засагт бий болох нэгдсэн бүтэц, зохион байгуулалтыг нарийвчлан судалж санхүүгийн капиталыг бий болгох шаардлагатай.

Эдийн засгийн интеграцийн үйл явц нь сүүлийн арван жилд олон улсын худалдааны хүрээнд хамгийн илүү тогтвортой явагдах боллоо. Гэхдээ үйлдвэр аж ахуйн газруудын хооронд технологийн /үйлдвэрлэлийн/ солилцоо, урт удаан хугацааны хоршилт, хамтран гүйцэтгэх ажил эрчимжсэний үрээр бараа үйлчилгээний өсөлт нэмэгдэв. Дэлхийн таваарын зах зээл, үйлчилгээний зах зээлтэй нягт харилцан уялдах болж байна. Монгол улс АНД болон ЗХА-ийн интеграцийн салшгүй нэг хэсэг болохын хувьд худалдааны бодлогыг дотооддоо цэгцэлж бүс нутгийн орнуудын худалдааны бодлого, бүтэц зохион байгуулалттай уялдуулан зохицуулах шаардлага гарч байна.

Санхүүгийн капиталыг бий болгох нь

Санхүүгийн капитал нь зах зээлийн үед эдийн засгийн үйл явцыг зохицуулах гол хүчин зүйл болохын хувьд улс орны эдийн засагт интеграцийн процессыг хэрэгжүүлэх үндсэн механизм болох ёстой.

Санхүүгийн капитал нь аж үйлдвэрийн хувь нийлүүлэгчдийн капитал банкны капиталтай нэгдэж байгаа процессын мөнгөн хэлбэрээр илэрхийлэгдэх хэсгийг нэрлэж байна.

Дэлхий дахины хөгжлийн явцаас харахад капиталын төвлөрөл, шилжилт хөдөлгөөн, санхүү, аж үйлдвэрийн корпорацуудын нэгдмэл үйл ажиллагаа нь тухайн улсын хил хязгаараас хальж улмаар үндэсний болон дэлхийн эдийн засагт онцгой үүрэг гүйцэтгэх болов. Өнөөгийн нөхцөлд санхүүгийн капиталыг бий болгох гол хэлбэр нь санхүү-аж үйлдвэрийн бүлэглэл бөгөөд энэ нь цаашлаад олон улсын эдийн засгийн байгууллагууд, тухайлбал, үндэстэн дундын банк үүсэн бий болох үндсэн нөхцөл болж байна.

Манай улсад 1990-ээд оноос эдийн засгийг санхүүгийн аргаар удирдах, чөлөөт зах зээлийг бий болгох эхний оролдлогууд хийгдсэн боловч үнэндээ хүн бүрийг хувийн өмчтэй болгохыг яаран томоохон үйлдвэрүүдийг жижиглэн хуваасан нь оновчтой арга биш байлаа. Энэ нь манай төр засаг, улс орныхоо эдийн засгийг удирдах зарим үүрэг функцээсээ татгалзсантай адил болсон юм. Энэ үед үйлдвэрүүдийн акцийг үнэт цаас гэх тасалбараар хувь хүмүүс болон ажилчдад хуваарилан өгөх болсноор хүн болгон ажилладаг ажилладаггүй машин техник, байшин сав, эд хөрөнгийн эзэн байхыг л хүсэж байсан бөгөөд үйлдвэрүүд нь технологийн шинэчлэл, өргөтгөл хийх, түүхий эдээ худалдан авахаас гадна эргэлтийн хөрөнгийг бүрдүүлэх боломжгүй болж зогсоход хүрсэн юм. Харин ч ингэснээрээ өөрийн хөрөнгө мөнгийг зарцуулаагүй хувьцаа эзэмшигчид гэгдэх үйлдвэрийн менежментийн болон цаашдын хөгжлийн асуудалд хариуцлага хүлээж санаа тавьдаггүй идэвхгүй хэсгийг төрүүлсэн гэж хэлж болно.

Ийнхүү манайд зах зээлийн баримжаат эдийн засгийн бүтцийг бий болгох анхны үеэс л санхүүгийн капиталын гүйцэтгэх үүрэг ролийг дутуу үнэлсэн нь харагдаж байна. Юуны өмнө санхүүгийн капитал нь хөрөнгө мөнгийг нийтгэн интеграцийн хэлбэрт оруулж байдаг билээ.

Орчин үед аж ахуйн үйл ажиллагааг интеграцчлах дэлхий нийтийн ерөнхий хандлага нь хөгжилтэй орнуудаас хөгжиж байгаа орнуудад капитал оруулах явдал бөгөөд тэр нь тухайн орны хөгжилд хүчтэй түлхэц өгч байна.

Монгол улсад үйлдвэр санхүүгийн бүлэглэл байгуулахад зохион байгуулалтын дараахи ажлуудыг авч хэрэгжүүлэх нь зохистой. Үүнд:

- Төр засгаас зах зээлийн үйл явцыг удирдан зохицуулах ажлыг хүчтэй болгох,
- Аж ахуйн буюу захиргааны нэгжүүдийн уялдаа холбоог сайтар зохицуулах механизмыг бий болгож, журмыг хуульчилж өгөх,
- Хөрөнгө мөнгө, төрөл бүрийн томоохон үйлдвэрийг аль болох нэгдмэл томоохон хүч болгохыг зорих,
- Томоохон үйлдвэрүүдийн хувьчлалд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, таатай нөхцөл олгох,
- Үйлдвэрийн хөгжлийг дэмжих Засгийн газрын буюу гадаадын хөрөнгө оруулалттай банк байгуулах, төр засгаас дэмжлэг үзүүлэх,

- Банкуудыг нэгтгэж үйлдвэрийн акцуудыг худалдах, ингэснээр үйлдвэр санхүүгийн программыг хангаж мөнгөний эргэлтийг хянах боломжтой болгох юм.

Ер нь дэлхийн практикт эдийн засаг, улс төрийн өргөн цар хүрээтэй олон талын хамтын ажиллагаа явуулахад тухайн орнууд эдийн засгийн ойролцоо систем /аж ахуйн загвар/ бий болгох явдал чухал байдаг. Иймээс Зүүн Хойд Азийн бүс нутгийн хамтын ажиллагаанд шинэ тутам орж буй орнууд дотооддоо зах зээлийн механизмыг жинхэнэ ёсоор төлөвшүүлэн, интеграцийн бүтцийг бий болгоход бүс нутгийн тэргүүний хөгжилтэй зах зээл хөгжсөн АНУ, Япон, БНСУ зэрэг оронтой олон талт хамтын ажиллагааг идэвхтэй явуулах нь зохистой.

ЗХА-ийн интеграци хөгжихөд улс төр, эдийн засгийн харилцан хамаарал бүхий хоёр тал байгаа бөгөөд энэ бүс нутгийн эдийн засгийн интеграцийн хөгжлийг улс төрийн асуудлаас нь ангид авч үзэх боломжгүй юм. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа, аюулгүй байдлын асуудлыг ЗХА-ийн орнуудын засгийн газрын түвшинд ярилцах механизм бий болгох шаардлагатай бөгөөд үүнд АНУ, НҮБ-ын оролцоо ч чухал юм.

Монгол орны хувьд Зүүн Хойд Азийн бүс нутгийн орнуудтай "Түмэн гол" болон бусад төслийн хүрээнд хамтран ажиллахаас гадна нэгэнт бүрэлдсэн үйлдвэрлэх хүчний тогтолцоо, байгалийн ба мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, хүн ардын боловсрол, шинжлэх ухааны түвшин, гадаад улс оронтой хамтран ажиллаж ирсэн туршлагад тулгуурлан өөрийн орны ашиг сонирхлыг бодитойгоор тодорхойлсон хөгжлийн загвар боловсруулан ажиллах нь зүйтэй санагдана.

The article deals with the fact that in order to intensify Mongolian involvement in the Northeast Asian economic cooperation there is a need to form integrational structures domestically. It is proposed to draw concrete plan and design integration model co-related with restructuring process while taking into account existing circumstances of socio – economic character. It is also proposed that beside participating in Tumen river project the country is to follow development model tailored to its needs, embracing existing production force system, recources, education level of people, scientific level reached and experience accumulated in relations with foreign countries.